



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/319

Мөрөн сум

Гамшгаас хамгаалах орон тооны бус алба,
мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6, 32.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Гамшгаас хамгаалах орон тооны бус албад мэргэжлийн ангийг доорх бүтэцтэйгээр шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Гамшгаас хамгаалах албад:

- Эрүүл мэндийн алба
- Зам, тээврийн алба
- Санхүү, хангалтын алба
- Түлш, эрчим хүчний алба
- Хэв журам сахиулах алба
- Мал эмнэлгийн алба
- Хэвлэл, мэдээллийн алба
- Хүнс, хөдөө аж ахуйн алба
- Барилга, хот байгуулалтын алба
- Хүн ам, нийгмийн хамгааллын алба
- Мэдээлэл, харилцаа, холбооны алба
- Байгалийн болон цацраг, химийн аюулыг үнэлж мэдээлэх алба

Тусгай зориулалтын мэргэжлийн анги:

- Хөвсгөл Дулааны станц ТӨХК
- Хөвсгөл Ус суваг ХХК
- Улаан загалмайн хороо
- Хөвсгөл АЗЗА ТӨХК
- Хөвсгөл Зам ХХК
- Улсын бүртгэлийн хэлтэс
- Зооноз өвчин судлалын төв
- Хот тохижилт үйлчилгээний төв
- Мөрөн Нисэх буудал
- Хөвсгөл аймаг дахь Нефть хангамжийн салбар /Ник Петровис ХХК/
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар

2. Гамшгаас хамгаалах албадын, гүйцэтгэх үүргийг хавсралтаар баталсугай.

3. Тусгай зориулалтын мэргэжлийн ангиуд Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 75 дугаар тушаалыг мөрдөж ажилласугай.

671 1010642

2.

4. Гамшгаас хамгаалах орон тооны бус албад, мэргэжлийн ангиудыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ё.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.

5. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн "Гамшгаас хамгаалах орон тооны бус албыг шинэчлэн байгуулах тухай" А/266 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ, ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ  М.ХУЯГБААТАР



ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБАДЫН
ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Аймгийн Гамшгаас хамгаалах албад /цаашид алба гэх/ нь холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг, улсын албадын болон Онцгой байдлын ерөнхий газрын даргын шийдвэрийг хэрэгжүүлэхдээ дор дурдсан нийтлэг болон мэргэжлийн дагуу гүйцэтгэх үүргийг хэрэгжүүлж ажиллана. Гамшгаас хамгаалах албаны дарга нь аймгийн Онцгой комиссын гишүүн байна.

Нэг. Албадын гүйцэтгэх нийтлэг үүрэг

1. Онцгой байдлын ерөнхий газраас боловсруулан гаргасан бүтэц зохион байгуулалтын чиглэлийг үндэслэн салбарынхаа онцлог байдалд нийцүүлэн удирдлагын бүрэлдэхүүнийг тушаалаар томилж, тэдгээрийг гүйцэтгэх үүрэгт нь сургаж, дадлаажуулах, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах
2. Салбарынхаа онцлогт зохицуулан гамшгаас хамгаалах албаны мэргэжлийн ангийг байгуулах, тэдгээрийн сургалт бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж шаардагдах багаж техник, хэрэгсэл материалаар хангах
3. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, тодотгол хийх
4. Эрхэлсэн салбарынхаа хэмжээнд гамшгаас хамгаалах арга хэмжээг жилээр төлөвлөж хэрэгжилтийг зохион байгуулах
5. Гамшгийн үед хариуцсан салбарынхаа чиглэлээр үйлдвэрлэлийн тогтвортой ажиллагааг хангах арга хэмжээний судалгаа, үнэлгээг хийлгэх, хэрэгжилтийг зохион байгуулах
6. Албадын удирдлага, штабын бүрэлдэхүүн нь үүсэж болзошгүй гамшгийн нөхцөл байдлыг үнэлж, авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулж баталгаажуулах, томилгоот бүрэлдэхүүний дадлага ур чадварыг дээшлүүлэх зорилгоор штабын бэлтгэл сургуулийг тогтмол явуулах
7. Нийтийн болон хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, аврах ажлын багаж техник хэрэгслийг тогтмол бэлэн байлгах
8. Гамшгийн голомтод нэрвэгдсэн хүн амд тусламж үзүүлэх, сургалт явуулах, аврах ажилд шаардагдах тоног төхөөрөмж, багаж, эм тарилга болон бусад бараа материалын нөөцийг бүрдүүлэх, хадгалах ажлыг мэргэжлийн дагуу зохион байгуулах
9. Гамшгаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулан хэрэгжүүлэх талаар гадаад орнуудад хэрэглэж байгаа тэргүүний арга технологи, техник хэрэгслийг судалж өөрийн орон нутгийнхаа онцлогт тохируулан нэвтрүүлэх
10. Гамшгаас хамгаалах штаб, дээд шатны байгууллага штабуудаас зохион байгуулж байгаа сургууль дадлагад оролцож тэдгээртэй болон бусад албадтай харилцан ажиллагааг зохион байгуулж, холбогдох асуудлыг хамтран шийдвэрлэх арга замыг боловсруулж хэрэгжүүлэх
11. Албаны жилийн ажлын тайлан, хугацаат мэдээг тогтоосон хугацаанд нь гамшгийн үед үүрэг гүйцэтгэсэн бол дүн мэдээг тухай бүр нь аймгийн Онцгой комисс, Онцгой байдлын газарт ирүүлж байх.

Албадын хүлээх үүрэг

Нэг. Байгалийн болон цацраг, химийн аюулыг үнэлж, мэдээлэх алба

1. Байгаль цаг агаарын аюултай үзэгдлийн тухай урьдчилсан мэдээгээр хангах
2. Агаар, хөрс, усан дахь цацрагийн бохирдолт, химийн хордолтын болзошгүй өөрчлөлтийн тухай мэдээллээр хангах
3. Байгалийн аюулт үзэгдлийн тухай сансрын хиймэл дагуулын зургаар хангах
4. Байгалийн аюулт үзэгдэлд үнэлгээ хийх
5. Гамшгийн үед үүссэн цацраг, химийн хордолтын тухай мэдээг орон нутгаас болон олон улсын байгууллагуудаас хүлээн авч мэдээлэл солилцох.
6. Ус, хөрс, агаарт байгаа цацраг, химийн бодисын зөвшөөрөгдөх хэмжээ, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг судлан тогтоож, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан эсэхэд хяналт тавих, мэдээлэх

Хоёр. Эрүүл мэндийн алба

1. Хүний гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулах, харилцан ажиллах
2. Гамшгийн үед нэрвэгдэгсдэд эмнэлгийн тусламж үзүүлэх
3. Нэрвэгдэгсдэд болон хүний гоц халдварт өвчнөөр өвчилсөн иргэдийг эмчлэх, хээрийн эмнэлэг байгуулах, шаардлагатай эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, цус, цус орлох бүтээгдэхүүнээр хангах
4. Алан хядах ажиллагаанд ашиглаж болзошгүй биологийн хэрэгслийн талаарх мэдээлэл, учрах хохирлын мэдээллээр хангах
5. Гамшгийн үед үүсч болох эмнэлгийн нөхцөл байдлыг үнэлэх, эмнэлэг хамгаалалтын арга хэмжээг авах
6. Халдвар эсэргүүцэх болон ариун цэвэр, эрүүл ахуйн арга хэмжээг байгуулах, энэ талаар бусад албадтай харилцан ажиллах
7. Эмнэлгийн албаны хүч хэрэгслийг зохион байгуулж тэдгээрийг эм ороох, боох материал, эмнэлгийн хэрэгслээр хангаж, нэрвэгдэгсдэд цаг тутам эмнэлгийн тусламж үзүүлэхэд байнга бэлэн байлгах.

Гурав. Хүнс, хөдөө аж ахуйн алба

1. Үр тариа, төмс, хүнсний ногоо, тэдгээрийн шилмэл сорт, бэлчээрийг ургамлын хортон шавьж, цацрагийн, химийн хордолт, биологийн халдварлалтаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулах
2. Гамшгийн үед ашиглах усны нөөцийг бүрдүүлэх, нөхөн сэлбэх, хадгалах, хамгаалах
3. Бэлчээрийн зохион байгуулалт, мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийн талаар нэгдсэн мэдээллээр хангаж, зудын аюулаас мал сүргийг хамгаалах арга хэмжээг удирдан зохион байгуулах.

Дөрөв. Мал эмнэлгийн алба

1. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, зохион байгуулах, ажлын үр дүнг мэдээлэх
2. Мал, амьтны гоц халдварт өвчний голомтыг устгах арга хэмжээг мэргэжлийн удирдлагаар хангах

Тав. Мэдээлэл харилцаа холбооны алба

1. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиог төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хүн амд зарлан мэдээлэх ажлыг шуурхай зохион байгуулах
2. Харилцаа холбоо, мэдээллийн техник хэрэгслийг байнгын бэлэн байдалд байлгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх
3. Гамшгийн үед холбоогоор хангаж мэдээ мэдээллийг саадгүй дамжуулах нөхцөлийг бүрдүүлэх
4. Албаны удирдлага, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн холбогдох бусад ажилтныг зарлан мэдээллийн дохиогоор цуглуулах бүдүүвчийг бэлтгэн сургууль дадлагын үеэр тодотгох
5. Албаны үндсэн болон хөдөлгөөнт удирдлагын байрыг холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгслээр төхөөрөмжлөх ажлыг зохион байгуулах, тэдгээрийн ашиглалт хадгалалтад хяналт тавих
6. Гамшгийн голомтод үүссэн нөхцөл байдал, түүний өөрчлөлтийн талаарх мэдээ, мэдээллийг шуурхай цуглуулах дамжуулах, мэргэжлийн ангиудтай тасралтгүй холбоо зохион байгуулах
7. Өөрийн нутаг дэвсгэрт байгаа холбоо, мэдээллийн бүх төрлийн техник хэрэгслийн судалгааг нэгтэн гаргаж, гамшгийн үед гамшгаас хамгаалах зориулалтаар хэрэглэх журмыг боловсруулан мөрдөж шаардлагатай үед тэдгээрийг төвлөрүүлэн ашиглах.

Зургаа. Түлш, эрчим хүчний алба

1. Гамшгийн үед онц чухал объектуудыг эрчим хүчээр тасралтгүй хангах
2. Түлш, эрчим хүчний үйлдвэрийн техникээс үүдэлтэй ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг зохион байгуулах
3. Эрчим хүчний салбар, станц түүний объектуудын тогтвортой ажиллагааг хангах, гамшгийн аюулаас учирч болзошгүй хохирол, эмзэг байдлын үнэлгээ судалгааг үндэслэн шаардлагатай арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх
4. Технологийн горим зөрчигдөх, түлш, шатахууны хомсдлоос болон бусад шалтгаанаар үүсч болзошгүй томоохон гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж тогтмол тодотгож ажиллах
5. Гамшгийн голомтод аврах ажил явуулахад эрчим хүчээр тасралтгүй хангах арга хэмжээг зохион байгуулах
6. Гамшгийн улмаас хүндрэл учрах тохиолдолд эрчим хүчний хангалтыг "Онцгой горимд" шилжүүлэх журам боловсруулж түүнийг гамшгаас хамгаалах дадлага, сургуулиар туршиж боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах.
7. Нөөц цахилгаан үүсгүүрүүдийн бэлэн байдлыг хангах, нөөц бүрдүүлэх

Долоо. Хэв журам сахиулах алба

1. Гамшгийн үед хэв журам сахиулахаар зргүүл постуудыг гарган аливаа гэмт хэргийг таслан зогсоох арга хэмжээг зохион байгуулах
2. Аврах хүч хэрэгслийг голомтод саадгүй нэвтрүүлэх
3. Гамшгийн үед сураггүй алга бологсдыг эрэн хайх, сурвалжлах, нас барагчдыг нэр, гэрийн хаягийг тогтоох ажлыг зохион байгуулах
4. Жил бүр авто тээврийн судалгаа гаргаж, дайчилгаагаар ажиллах тээврийн

хэрэгслийн бэлэн байдлыг шалгаж, баталгаа гаргаж өгөх.

5. Галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисын судалгаа бүртгэл хөтөлж тэдгээрийн аюулгүй байдалд хяналт тавьж ажиллах

6. Онц чухал объектуудын харуул хамгаалалтыг зохион байгуулах, хяналт тавих

7. Гамшгийн голомтод халдвар, цацрагийн болон химийн хордолтоос хамгаалах, хорио цээрийн дэглэм сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор харуул хамгаалалт зохион байгуулж үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах.

Найм. Хэвлэл мэдээллийн алба

1. Гамшгийн тухай зарлан мэдээллийн болон сэрэмжлүүлэх дохио, мэдээллийг хүн амын дунд ухуулга сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулах

2. Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах арга хэмжээний явц байдлын тухай мэдээ мэдээллийг хүн амд тайлбарлан таниулах

3. Онцгой байдлын газар болон албадаас урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээний тухай бэлтгэсэн ухуулга сурталчилгааг хүн амд шуурхай хүргэх

4. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохионууд, сэрэмжлүүлэх мэдээллүүд, тэдгээрийн дагуу ажиллах, нийтээр дагаж мөрдүүлэхээр тогтоосон журмыг сахин биелүүлэх талаар суртал нэвтрүүлэг, сурталчилгааны ажлыг зохион байгуулах.

5. Иргэдэд нэгдсэн урсгалаар бодит мэдээллийг тогтмол хүргэх

6. Бусад хэвлэл мэдээллийн байгууллагуудын ажлын уялдааг хариуцан зохицуулах, удирдлагаар хангах

Ес. Барилга, хот байгуулалтын алба

1. Инженер геологийн хайгуул, байгууламжид нуралт, эвдрэл, гарсан ослын шалтгааныг тогтоох, холбогдох арга хэмжээ авах ажлыг зохион байгуулах

2. Хот суурин газар, объектын ерөнхий ба нарийвчилсан төлөвлөгөөнд гамшгаас хамгаалах асуудлыг тусган хэрэгжүүлэх

3. Газрыг үр ашигтай зохистой ашиглах, хамгаалах нийтлэг шаардлагыг мөрдүүлж ажиллах

4. Газрын төлөв байдал байгалийн аясаар болон хүний үйл ажиллагааны улмаас хөрсний үржил шим буурах, газрын ургамлын бүрхэвч талхлагдах, хөрс элэгдэх, эвдрэх хуурайших, намагших, давсжих, бохирдох, хордохоос сэргийлэх арга хэмжээ авах ажлыг зохион байгуулах

5. Газар түүний баялаг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах явцад байгаль орчинд серег нөлөө үзүүлэхгүй байх ажлыг зохион байгуулах


6. Хот тосгон, барилга байгууламж барих, өргөтгөх зураг төсөлд гамшгаас хамгаалах шаардлагыг тусгуулж тэдгээрийн угсралтын явцад хяналт тавьж гүйцэтгүүлэх

7. Хот суурин, барилга байгууламж, холбооны байгууламж, зам, гүүр, тээврийн хэрэгсэлд үүсэх хөнөөлийн зэрэг, хүн амд учирч болзошгүй хохирол, аврах ажлын багтаамжийг тооцоолж, инженерийн хангалтыг зохион байгуулах

8. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн үйл ажиллагааг хариуцан ажиллах, төлөвлөгөө боловсруулах

Арав. Зам, тээврийн алба

1. Авто тээврийн болон бусад төрлийн тээврийн хэрэгслийн судалгааг аймаг, сумын хэмжээнд жил бүр гаргаж тэдгээрийг нэгтгэн Шуурхай штабт өгөх

- 
2. Гамшгийн үед шаардагдах авто тээврийн хэрэгслийн судалгааг гарган байгууллага, аж ахуйн нэгж, жолооч нартай гэрээ хийж бэлэн байдлыг хангуулах
 3. Гамшгийн үед шаардагдах шатах, тослох материалыг шатахуун түгээх станцуудтай гэрээ хийж нөөцийг бий болгох
 4. Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх ажиллагаанд шаардагдах тээврийн хэрэгслийг дайчлан ажиллуулах ажлыг хэв журам сахиулах албатай хамтран зохион байгуулах
 5. Гамшгийн үед ашиглагдах зам гүүр, машин механизм, тээврийн хэрэгслийн байршил, хүчин чадлын судалгааг гаргаж тэдгээрийг дайчлан ажиллах боломжийг тодорхойлж бэлэн байдлыг хангах
 6. Гамшгийн голомтод аврах ажил явуулахад инженерийн хангалтын арга хэмжээг зохион байгуулах.

Арван нэг. Хүн ам, нийгмийн хамгааллын алба

1. Хүн амын дэлгэрэнгүй судалгааг гаргаж, гамшгаас хамгаалах арга хэмжээнд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, өсвөрийн бүлгэм байгуулах
2. Хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдэд ээлтэй орон зайг бий болгох, хүүхэд хамгааллын асуудлаар бусад мэргэжлийн ангиудтай хамтран ажиллах, сургуульд элсэхийн өмнөх болон сургуулийн насны хүүхдийн боловсролыг тасралтгүй явуулах ажлыг зохион байгуулах
3. Гамшиг, ослын үед өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, тэдэнд үзүүлэх нийгмийн халамжийн асуудлыг зохион байгуулах, голомтын бүсээс эхний ээлжинд нүүлгэн шилжүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах.

Арван хоёр. Санхүү, хангалтын алба

1. Гамшгийн үед шаардагдах хоол хүнс, шатах тослох материал орон байр бусад шаардагдах зардлын асуудлыг яаралтай тооцоолж холбогдох шийдвэрийг гаргуулах
2. Гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн анги, байгууллага, хуулийн этгээдийн ажлын уялдааг хангуулах
3. Шаардагдах бүх төрлийн нөөцийн судалгааг холбогдох байгууллагуудаас гаргуулж зардлын тооцоог нарийвчлан гаргах
4. Нөөцийн хомсдолтой үед шаардлагатай дэмжлэгийг авах асуудлыг шийдвэрлүүлэх санал гаргах